

ХОРШООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНГАРАГ

(санал-загвар)

Хоршооны тэргүүлэгч (хяналтын зөвлөлийн гишүүн) би энэхүү нэр төртэй, хамтрагч гишүүдийнхээ итгэл хүлээсэн албан тушаалд сонгосон хоршооныхоо ашиг тусын төлөө идэвх чармайлтаа дайчлан ажиллахаа ТАНГАРАГЛАЖ байна.

Би:

- шудрага, хичээнгүй байж
- хоршооныхоо ашиг сонирхлыг хувийнхаасаа дээгүүр тавьж
- хоршооны ажил хэрэгт өөриймсгөөр хандаж
- тэргүүлэгчдийн (хяналтын зөвлөлийн) хурал болон хоршооны бусад ажилд цаг зав гаргаж, тэргүүлэгчдийн (хяналтын зөвлөлийн) бүх хуралд ажил хэрэгчээр бүрэн оролцож
- хоршооныхоо үйл ажиллагаа болон засаглалыг бүх талаар сайжруулж
- бусдын хэлснээр бус, өөрийн зөв байр сууринд бат байж
- удирдлагын багийн нээлттэй гишүүн байж
- асуудлыг олон талаас нь хэлэлцэн олонхийн саналаар шийдвэрлэж, гарсан шийдвэрийг дагаж мөрддөг хамтын удирдлагын зарчмыг баримталж
- зөвхөн өөрийн бус, нийт тэргүүлэгчдийн (хяналтын зөвлөлийн гишүүдийн) санал бодол, шийдвэрийг бусад гишүүддээ танилцуулж
- хоршоогоо гишүүдийнх хэвээр нь хадгалж, дарга, захирлын хоршоо болохоос сэргийлж
- хоршооны нийтлэг эрх ашгийг төлөөлж
- хоршооны үйл ажиллагаанд түүний зарчмуудыг хангуулах, шинэлэг, бүтээлч арга барил нэвтрүүлэхийн төлөө чадах бүхнийг хийж
- нээлттэй, ил тод байдлыг хангаж
- хоршооны тэргүүлэгчийн (хяналтын зөвлөлийн гишүүний) ажил, үүргээ бүрэн дүүрэн биелүүлж ажиллахаа БАТЛАН ИЛЭРХИЙЛЖ байна.

ГАРЫН ҮСЭГ (.....)